## Хүмүүнлэгийн ухааны (Сөүл) кампус

Мёнжи Их Сургуулийн Сөүл дэх кампус нь орчин үеийн убиквитос (хаанаас ч суралцах боломжтой) боловсролын дэвшилтэт орчин-той бөгөөд олон улсын түвшний боловсролыг оюутнуудад олгодог. Мөн Сөүл хотын их сургуулиуд олноор байрладаг Шинчон болон Хонда бүсэд ойрхон байрладаг тул оюутнууд шинэ санаа, бүтээлч сэтгэлгээгээ хуваалцаж хөгжүүлэхэд маш таатай орчныг бүрдүүлсэн байдаг. Сөүл кампуст Хүмүүнлэгийн ухааны сургууль, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Бизнесийн удирдлагын сургууль, Медиа ба хүний амьдралын сургууль, Хиймэл оюун ухаан ба програм хангамжийн сургууль, Ирээдүйн нэгдмэл судалгааны сургуулиуд байдаг.

## Байгалийн ухааны (Ёнгин) кампус

Мёнжи Их Сургуулийн Ёнгин дахь кампус нь зөвхөн баялаг боловсролын дэд бүтэцтэйгээс гадна дэлхийн хамгийн том  хагас дамжуулагч (semiconductor) үйлдвэрлэлийн бүс, мөн Мугунхуа хиймэл дагуулын хяналты н төв зэрэг өндөр технологийн үйлдвэрлэлийн байгууламжуудтай ойр байрладаг. Ёнин хотын боловсрол болон соёлын баялаг орчинд түшиглэсэн Мёнжи их сургуулийн байгалийн ухааны кампус нь маш сайн хүртээмжтэй (Сөүлээс ойролцоогоор 1 цаг), байгальд ээлтэй сургалтын орчин, мөн орчин үеийн дэвшилтэт сургалтын байгууламжуудыг бүрэн хангасан байдаг. Ёнгин кампуст Архитектурын сургууль, Хими · амьдралын шинжлэх ухааны сургууль, Хагас дамжуулагч · ICT нэгдмэл  технологийн сургууль, Ухаалаг систем инженерийн сургууль, Спорт урлагийн сургуулиуд байдаг.

## Солонгос хэлний боловсролын төвийн танилцуулга

- **Кампус :** Хүмүүнлэгийн ухааны (Сөүл) кампус, Байгаль ухааны ухааны (Ёнгин) кампус
- **Анги дүүргэлт:** Нэг ангид ойролцоогоор 15 оюутан
- **Сургалтын шат :** 1-р түвшин (анхан шат), 2-р түвшин (суурь шат), 3-р түвшин (дунд шат), 4-р түвшин (дунд шат), 5-р түвшин (ахисан шат), 6-р түвшин (ахисан шат)
- **Хичээлийн цаг :** Нэг улирал 10 долоо хоног, долоо хоногт 5 өдөр (Даваа–Баасан), өдөрт 4 цаг хичээл — нийт 200 цаг
- **Хичээлийн цагийн хуваарь :** 1–2-р түвшин - 14:00–18:00, 3–6-р түвшин - 09:00–13:00
- **Сурах бичиг :** Сөүлийн их сургуулийн хэвлэлийн Солонгос хэл сурах бичиг (Student Book A/B, Workbook A/B)
- **Сургалтын хэл :** Солонгос хэл
- **Анги хуваарилалт :** Бичгийн болон ярианы шалгалтын дүнгээр суралцагчийн түвшинд тохируулан ангид хуваарилна.

## Төрөл бүрийн арга хэмжээ, үйл ажиллагаа

- **Танилцуулах өдөрлөг :** Солонгос хэлний боловсролын төвийн танилцуулга, Солонгост амьдрахад хэрэгтэй мэдээлэл болон хэлний сургалтын визийн талаар анхаарах зүйлсийг тайлбарлана.
- **Соёлын өдөрлөг үйл ажиллагаа :** Төрөл бүрийн соёлын өдөрлөг арга хэмжээг зохион байгуулна. (улиралд 1 удаа, сургалтын төлбөрт багтсан).

- **Төгсөлтийн баяр :** Төгссөн оюутнуудад Мёнжи их сургуулийн Солонгос хэлний түвшин төгссөн сертификат, Сурлагын амжилтын шагнал, Бүрэн ирцийн шагнал, Сургуулиа идэвхтэй сурталчилсан оюутны шагнал зэргийг гардуулна.
- **Нэмэлт хичээл :** 1-р түвшний хичээлд хүндрэлтэй байгаа оюутнуудад зориулсан бүлгийн нэмэлт хичээл зохион байгуулна.
- **Rolling Paper :** Дурсамж, сэтгэлийн үгээ хуваалцах тусгай арга хэмжээ.

## Тэтгэлэг

- Сурлагын амжилтын тэтгэлэг
- Сургуулиа идэвхтэй сурталчилсан тэтгэлэг
- OECD-ийн орнуудын оюутнуудад зориулсан тэтгэлэг

## Элсэгчид тавигдах шаардлага

- Ахлах сургууль төгссөн буюу түүнээс дээш боловсролтой байх (хэлний бэлтгэлийн виз шаардлагатай тохиолдолд)
- Сүүлд төгссөн сургуулиа төгсөөд 2 жилээс хэтрээгүй байх

※ Хэрэв сүүлд төгссөн сургуулиа төгсөөд 2 жилээс дээш хугацаа өнгөрсөн бол тухайн хугацаанд юу хийж байсан талаар тайлбарлах баримт бичиг ирүүлэх шаардлагатай. (жнь: Ажлын тодорхойлолт / Ажлын туршлагын тодорхойлолт, Хэлний сургалтын гэрчилгээ гэх мэт)

## Бүртгэлийн журам

① Солонгос хэлний боловсролын төвийн вебсайтад гишүүнээр бүртгүүлэх
② Өргөдлийн маягт бөглөж, шаардлагатай баримт бичгийг ирүүлэх
③ Баримт бичгийн шалгалт болон тэнцсэн оюутнуудыг зарлах
④ Эцсийн шатанд тэнцсэн оюутнууд сургалтын төлбөр төлөх
⑤ Бүртгэлийн хураамж болон сургалтын төлбөр төлөх
⑥ Элсэлтийн зөвшөөрлийн бичиг олгох
⑦ Виз мэдүүлэх (оюутан)
⑧ Солонгост ирэх

## Холбоо барих


**Хүмүүнлэгийн ухааны (Сөүл) кампус**

**Хаяг :** 서울특별시 서대문구 거북골로 34 명지대학교 행정동(5번건물) 4층 한국어교육센터 (우편번호: 03674)

**Имэйл :** Шинэ элсэгч оюутан : kli@mju.ac.kr
Одоо суралцаж буй оюутан, багш : mjuklec@mju.ac.kr

**Холбоо барих утас :** Шинэ элсэгч оюутан 02-300-1499
Одоо суралцаж буй оюутан 02-300-1515

**Байгалийн ухааны (Ёнгин) кампус**

**Хаяг :** 경기도 용인시 처인구 명지로 116 명지대학교 제2공학관 2층 외국인학생지원팀 (우편번호: 17058)

**Имэйл :** Шинэ элсэгч оюутан : kli@mju.ac.kr
Одоо суралцаж буй оюутан, багш : mjuklec@mju.ac.kr

**Холбоо барих утас :** Шинэ элсэгч оюутан 02-300-1499
Одоо суралцаж буй оюутан 02-300-1515




### 2026 оны хичээлийн жилийн

# Солонгос хэлний бэлтгэлийн шинэ оюутны элсэлт




**믿음의 대학, 믿을 수 있는 인재!**

Your future Begins Here! MyongJi University

명지대학교 한국어교육센터

## Бүрдүүлэх материалын заавар

**(Гадаадаас өргөдөл гаргагч, D-4-1)**

| Бүрдүүлэх материал | Тайлбар |
|---|---|
| **[2 улирал бүртгүүлэх улсын бүрдүүлэх материал]** | |
| 1. Өргөдлийн маягт | Онлайнаар өргөдлийг бөглөж, хэвлэсний дараа гарын үсэг зурах |
| 2. Паспортын хуулбар (өргөдөл гаргагч) | |
| 3. Сүүлд төгссөн сургуулийн диплом болон дүнгийн хуулбар | |
| 4. Сүүлд төгссөн сургуулийн апостиль гэрчилгээ эх хувь | Доорх хүснэгтийг хамрана уу. |
| 5. 10,000,000 воноос дээш үлдэгдэлтэй банкны тодорхойлолт (өргөдөл гаргагчийн) эх хувь<br>※ Улс бүрийн виз авахад шаардлагатай банкны тодорхойлолтын жишээг шалгаж, хугацааг баталгаажуулсны дараа илгээх | Бүртгэл эхэлснээс хойш 30 хоногийн дотор олгогдсон баримт байх ёстой.<br>→ Хэрэв эцэг эхийн нэр дээр бол 6,7-р материалыг нэмэлтээр ирүүлнэ үү. |
| **[4 улирал бүртгүүлэх улсын бүрдүүлэх материал]** | |
| 6. Эцэг эхийн иргэний үнэмлэхийн хуулбар тус бүр | Англи нэрийг бичсэн байх |
| 7. Төрөл садангийн лавлагаа эх хувь (эсвэл төрсний гэрчилгээ) | Англи нэрийг бичсэн байх |
| 8. Санхүүгийн батлан даагч (эцэг эх)-ийн ажлын тодорхойлолт болон орлогын тодорхойлолт эх хувь | |
| 9. Солонгос иргэний батлан даалтын бичиг болон ажлын тодорхойлолт эх хувь<br>※ Хуулийн фирмийн нотариатын баталгаажуулалт заавал хийлгэсэн байх | Зөвхөн нэмэлт шаардлага гарсан тохиолдолд |

※ Бүх материалыг солонгос, англи эсвэл хятад хэлээр ирүүлэх шаардлагатай.
(Бусад хэл дээр бол орчуулга болон нотариатын баталгаажуулалт шаардлагатай)

※ Материал шалгах явцад нэмэлт материал шаардаж болно.

※ Ирүүлсэн материалыг буцаан олгохгүй.

### Улс бүрийн апостиль гэрчилгээний заавар

① Апостиль (Apostille)-ийн конвенцид нэгдсэн улс: Апостиль гэрчилгээны эх хувь

② Хятад
- Хятадын боловсролын баталгаажуулалтын тайлан (chsi.com.cn эсвэл cdgdc.edu.cn)
- Мэргэжлийн/техникийн ахлах сургууль төгссөн бол сургуулийн баталгаажуулалтын вэбсайтыг заавал шалгаж материалыг ирүүлэх

③ Апостиль (Apostille)-ийн конвенцид нэгдээгүй улс: Тухайн усад суугаа БНСУ-ын Консул эсвэл БНСУ-д суугаа өөрийн улсын дипломат төлөөлөгчийн газрын консулын баталгаажуулалт авсан боловсролын бичиг баримт

※ Бүх Апостиль гэрчилгээ зэрэг материалын эх хувийг шуудангаар илгээх хэрэгтэй.

### 4 улирал бүртгүүлэх шаардлагатай улсын жагсаалт

Гана, Нигери, Непал, Мьянмар, Бангладеш, Вьетнам, Монгол, Шри-Ланка, Узбекистан, Украин, Иран, Египет, Энэтхэг, Индонез, Казахстан, Киргизстан, Тайланд, Пакистан, Перу, Филиппин, Гвиней, Мали, Этиоп, Уганда, Камерун гэх мэт.

※ Хууль зүйн яамнаас зарласан 21 улс болон визийн хяналтын 5 улс-ыг харна уу.

※ Тухайн улсад нэмэлт материал шаардагдаж болно.

## Хичээлийн хугацаа болон бүртгэлийн хуваарь



### 2026 оны хичээлийн жил

| Улирал | Хичээлийн хугацаа | Бүртгэлийн хугацаа | Шинэ оюутны анги хуваарилах шалгалт (бичгийн) | Шинэ оюутны анги хуваарилах шалгалт (ярианы) | Танилцуулах өдөрлөг |
|---|---|---|---|---|---|
| Хаврын улирал | 2026.03.11.(Лха) ~ 2026.05.20.(Лха) | 1-р ээлж 2025.12.08.~2025.12.31.<br>2-р ээлж 2026.01.01.~2026.01.16. | 2026.02.11.~12. | 2026.02.23. | 2026.03.09. |
| Зуны улирал | 2026.06.09.(Мя) ~ 2026.08.18.(Мя) | 1-р ээлж 2026.03.11.~2026.03.31.<br>2-р ээлж 2026.04.01.~2026.04.17. | 2026.05.14.~15. | 2026.05.22. | 2026.06.05. |
| Намрын улирал | 2026.09.04.(Ба) ~ 2026.11.18.(Лха) | 1-р ээлж 2026.06.09.~2026.06.30.<br>2-р ээлж 2026.07.01.~2026.07.16. | 2026.08.11.~12. | 2026.08.19. | 2026.09.02. |
| Өвлийн улирал | 2026.12.07.(Да) ~ 2027.02.19.(Ба) | 1-р ээлж 2026.09.04.~2026.09.30.<br>2-р ээлж 2026.10.01.~2026.10.16. | 2026.11.12.~13. | 2026.11.19. | 2026.12.03. |

### 2027 оны хичээлийн жил

| Улирал | Хичээлийн хугацаа | Бүртгэлийн хугацаа | Шинэ оюутны анги хуваарилах шалгалт (бичгийн) | Шинэ оюутны анги хуваарилах шалгалт (ярианы) | Танилцуулах өдөрлөг |
|---|---|---|---|---|---|
| Хаврын улирал | 2027.03.10.(Лха) ~ 2027.05.21.(Ба) | 1-р ээлж 2026.12.01.~2026.12.24.<br>2-р ээлж 2026.12.28.~2027.01.14. | 2027.02.10.~11. | 2027.02.22. | 2027.03.08. |
| Зуны улирал | 2027.06.08.(Мя) ~ 2027.08.18.(Лха) | 1-р ээлж 2027.03.10.~2027.03.31.<br>2-р ээлж 2027.04.01.~2027.04.15. | 2027.05.10.~11. | 2027.05.24. | 2027.06.04. |
| Намрын улирал | 2027.09.03.(Ба) ~ 2027.11.23.(Мя) | 1-р ээлж 2027.06.01.~2027.06.24.<br>2-р ээлж 2027.06.28.~2027.07.08. | 2027.08.09.~10. | 2027.08.19. | 2027.09.01. |
| Өвлийн улирал | 2027.12.06.(Да) ~ 2028.02.22.(Пү) | 1-р ээлж 2027.09.01.~2027.09.23.<br>2-р ээлж 2027.10.01.~2027.10.14. | 2027.11.10.~11. | 2027.11.24. | 2027.12.02. |

※ Сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалан хуваарьт өөрчлөлт орж болно.

## Сургалтын төлбөр

| Улирал | 2026 оны хичээлийн жилийн зуны улирал ~ өвлийн улирал |
|---|---|
| Хүмүүнлэгийн ухааны (Сөүл) кампус | 1,520,000вон / улирал |
| Байгалийн ухааны (Ёнгин) кампус | 1,320,000вон / улирал |

※ Гадаад оюутны даатгал, 4 ширхэг сурах бичиг, соёлын туршлагын үйл ажиллагааны 1 удаагийн зардал багтсан.

※ Сургалтын төлбөр жил бүр хаврын улиралд нэмэгдэх боломжтой бөгөөд нэмэгдсэн дүнг нэмж төлөх шаардлагатай. (зөвхөн шинэ элсэгчдэд хамаарна)

